



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/287

Алтай хот

**Газрын байршил, зориулалт өөрчлөх  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.1, 9.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд эзэмшил газрын байршил, зориулалт өөрчлөх хүсэлт ирүүлсэн Ц.Нямсүрэнгийн эзэмшиж байгаа газрын зориулалтыг шатахуун түгээх станцын зориулалттай болгон өөрчилж, байршлыг хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшсэн Ц.Нямсүрэнгийн мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/300 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 3 дугаарт бичигдсэн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

**ИРГЭН Цогт-Очир ОВОГТОЙ Нямсүрэн ( ЧР78011563 ) - ИЙН  
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Наж талбарын дугаар: 820800  
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Харзат баг



Аймгийн Засаг даргын  
2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн  
084 дугаар захирамжийн 9-р хавсралт

Огноо: 2023-4-20

Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цагүүд
1	5140037.487	290146.132	30.00	1-2
2	5140060.578	290126.979	65.00	2-3
3	5140102.076	290177.009	30.00	3-4
4	5140078.985	290186.167	65.00	4-1

Талбайн хэмжээ: 1950.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)